



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн /Орон нутгийн төсөв/ 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код:

ХӨА-2023/223/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум
2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317
Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99900662
Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: С.Гансүх
Утас: 95908400
Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.23 № 01/56
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Т.РАДНААБУД ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн халамжийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн халамжийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс халамжийн бусад /Цаатан иргэнд олгох тэтгэмж/, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ гэсэн 3 чиглэлээр нийт 738 иргэнд 1,190,678.0 мянган төгрөгийн халамжийн үйлчилгээг үзүүлжээ.

Аудитын гол асуудал

Тайлагналын дараах үйл явдлаар Үндэсний статистикийн хорооноос 2024 оны 3 дугаар сарын 1-ээс хүн амын амьжиргааны доод түвшнийг өмнөх оноос 58.4 хувиар нэмэгдүүлж хангайн бүсэд 447.5 мянган төгрөгөөр тогтоохоор төлөвлөж байгаа нь цаатан иргэдэд олгох тэтгэмжийн төсөв 504,900.0 мянган төгрөгөөр дутах эрсдэл үүсгээд байна.

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн санхүүгийн тайланд орон нутгийн төсвөөс санхүүждэг халамжийн үйлчилгээг хамруулан тайлагнасан ба улсын төсвөөс санхүүждэг халамжийн үйлчилгээг улсын хэмжээнд нэгтгэсэн санхүүгийн тайланд тайлагнадаг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ /ТӨГРӨГӨӨР/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
.	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0	0
.	АВЛАГА	0	0
33	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0	0
.	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0	0
.	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	0	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0	0
41	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0	0
41	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0	0
510301	Өмнөх үеийн үр дүн	0	0
51030100			
02	Өмнөх үеийн үр дүн орон нутаг	0	0
510302	Тайлант үеийн үр дүн	0	0
51030200			
02	Тайлант үеийн үр дүн орон нутаг	0	0
0	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	0	0
0	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	0	0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөр	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1303	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	962,545,160.00	1,190,678,000.00
130301	Улсын төсвийн санхүүжилтийн орлого	0	0
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого	962,545,160.00	1,190,678,000.00
14	Бараа, үйлчилгээний орлого	0	0
1401021	Орон нутгийн төсвийн хүүгийн орлого	0	0
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	962,545,160.00	1,190,678,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0	0
2603	Төсөвт төвлөрүүлэх	0	0
260301	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	0	0
260302	Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв	0	0
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ	962,545,160.00	1,190,678,000.00
2701021300	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	90,000,000.00	99,600,000.00
2701023000	ОНОТүшгэлсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	14,992,950.00	67,210,000.00
2702026000	Цаатан иргэдийн мөнгөн тэтгэмж	857,552,210.00	1,023,868,000.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	962,545,160.00	1,190,678,000.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	0	0

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1303	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО [2]+[3]	962,596,000.00	1,191,515,200.00
130301	Улсын төсвийн санхүүжилтийн орлого	0	0
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого	962,596,000.00	1,191,515,200.00
1401	Бараа, үйлчилгээний орлого [5]+[6]+[7]+[8]+[9]+[10]	0	0
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ТӨВ [1]+[4]	962,596,000.00	1,191,515,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ [13]+[14]+[15]+[16]	0	0
02701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ	962,596,000.00	1,191,515,200.00
2701021300	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	90,000,000.00	99,600,000.00
2701023000	ОНОТүшгэлсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	14,992,950.00	67,210,000.00
2702026000	Цаатан иргэдийн мөнгөн тэтгэмж	857,552,210.00	1,023,868,000.00
2603	Төсөвт төвлөрүүлэх [53]+[55]	50,840.00	837,200.00
260302	Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв	50,840.00	837,200.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	962,596,000.00	1,191,515,200.00
.	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0	0
.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээ	Хуримтлагдсан	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 01 сарын 1-ээрх үлдэгдэл	0	0	0	0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
7	Тайлант үеийн үр дүн	0	0	0	0
8	2022 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	0	0	0	0
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн /Орон нутгийн төсөв/ 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

14	Тайлант үеийн үр дүн	0	0	0	0
15	2023 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	0	0	0	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Сангийн орлого	Төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0	0
2	Сангийн үйл ажиллагааны зардал	1,191,515,200.00	1,190,678,000.00	837,200.00	99.92
6	Халамжийн сан	1,124,275,200	1,123,468,000	807,200.00	99.92
8	Олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээ	67,240,000.00	67,210,000.00	30,000.00	99.95
20	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ	1,191,515,200.00	1,190,678,000.00	837,200.00	99.93
	Мөнгө, түүнтэй өдилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0	0
	Мөнгө, түүнтэй өдилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0	0	0

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн 1 зөрчил¹ зөвлөмж өгсөн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцрон мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 –т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ...” заалттай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулж байх

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцрон мэдээлсэн байна.	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1						1	

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.